



ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
САЛБАР ЗӨВЛӨЛИЙН 2016 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2017.01.05

Сүхбаатар

Төрийн үйлчилгээний ил тод, шуурхай байдлыг ханган, төрийн албан хаагчдын ёс зүйн хариуцлагыг өндөржүүлж, цомхон, чадварлаг, үр дүнд чиглэсэн төрийн албыг бүрдүүлэх, төрийн албаны шинэтгэлийг орон нутагт хэрэгжүүлэх, төрийн удирдах албан тушаалтны манлайллыг дээшлүүлэхэд гол үйл ажиллагаагаа чиглүүлэн ажиллалаа.

Мөн аймгийн хэмжээнд **“Ил тод байдлыг хангах, ажлын хариуцлагыг дээшлүүлэх жил”** болгон зарлаж, 9 чиглэлийн 18 ажил арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүллээ. Салбар зөвлөлийн үйл ажиллагаатай холбоотой баримт бичгийн 8 хавтсыг бүрдүүлж, тогтоол, тэмдэглэл, албан бичиг, заавар журам, төрийн албан хаагчийн сургалтын баримт материалыг ангилан цэгцэлж жил бүрийн эцэст архивлах ажлыг хийж гүйцэтгэлээ.

Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөл нь тайлант онд 8 удаа хуралдаж, 20 асуудлыг хэлэлцэн төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоог нөөцөөс нөхөх, удирдах ажилтны сонгон шалгаруулалтын дүн, “Төрийн албаны тэргүүний ажилтан”-аар тодорхойлогдсон төрийн албан хаагчийн материалыг нягтлан хэлэлцэж уламжлах, салбар зөвлөлд хандсан өргөдөл гомдлыг хянан шийдвэрлэх, өргөдөл гомдлыг магадлан шалгасан дүгнэлт, салбар зөвлөлийн үйл ажиллагааны тухай зэрэг асуудлыг тухай бүр нь хуралдаанаараа хэлэлцэж шийдвэрлэлээ.

Төрийн албаны салбар зөвлөлийн
2016 оны хуралдааны тойм

№	Салбар зөвлөлийн хуралдаан	Хуралдаан болсон огноо	Хэлэлцсэн асуудлын тухай	Шийдвэрлэлт
1	Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн хуралдаан №01	2016.01.12	1.Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль зүйн хэлтсийн даргын албан тушаалд нэр дэвшигчийн дүгнэлт гаргах тухай	Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн дүгнэлтийг харгалзан Сэлэнгэ аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын 2016 оны Б/ дугаар тушаалаар Д.Ёндонжамцыг Хууль зүйн хэлтсийн даргын албан тушаалд томилсон.
2	Төрийн албаны зөвлөлийн	2016.01.25	1.Төрийн албаны салбар зөвлөлийн 2016 оны ажлын төлөвлөгөөнд	1.Салбар зөвлөлийн гишүүдийн саналыг тусган төслийн батлахаар тогтов.



Төрийн албаны зөвлөлийн
Сэлэнгэ аймаг дахь салбар зөвлөл



	салбар зөвлөлийн хуралдаан №02		<p>санал авах</p> <p>2. Төрийн албаны салбар зөвлөлд ирүүлсэн санал хүсэлтийн тухай</p> <p>а/ Сүхбаатар сумын иргэн Д.Баярхүү /БОГ-ийн саналын талаар/</p> <p>б/ Сүхбаатар сумын иргэн Г.Баасанжав /БСГ-аас ирсэн саналын тухай/</p> <p>в/ Алтанбулаг сумын иргэн М.Буяннэмэх</p> <p>/Санхүүгийн албанд ажилд авахгүй байгаа тухай/</p> <p>3."Төрийн албаны тэргүүний ажилтан" цол тэмдгээр шагнуулах тухай</p> <p>Баянгол сумын ахмад Н.Даваадоржийн тухай</p> <p>4. 2015 оныг "Төрийн албаны хаагчийн мэдлэг чадвар, ёс зүйг дээшлүүлэх" жил болгон зарласан жилийн ажлын дүнгийн тухай.</p> <p>5. ТАЗ-ийн өгсөн үүрэг чиглэлийн дагуу 2016 оныг "Ил тод байдлыг хангах, ажлын хариуцлагыг дээшлүүлэх жил" болгон зарлах тухай</p>	<p>2. Сүхбаатар сумын иргэн Д.Баярхүүгийн өргөдлийн дагуу Аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газрын дарга Б.Батзоригт албан тоот явуулахаар шийдвэрлэсэн.</p> <p>3. Сүхбаатар сумын иргэн Г.Баасанжавын өргөдлийн дагуу Аймгийн Прокурорын газарт ТАЗСЗ-ийн албан бичгээр нотлох баримтыг авах нь зүйтэй шийдвэрлэсэн.</p> <p>Алтанбулаг сумын ЗДТГ-ын даргад ТАЗСЗ-ийн албан бичгээр хариуг хүргүүлэхээр болсон.</p> <p>"Төрийн албаны тэргүүний ажилтан" цол тэмдгээр шагнуулах тухай</p> <p>Баянгол сумын ахмад Н.Даваадоржийн шагналын баримт бичгийг бүрдүүлэн Төрийн албаны зөвлөлд уламжлахаар тогтсон.</p> <p>4.2015 оныг "Төрийн албан хаагчийн мэдлэг чадвар, ёс зүйг дээшлүүлэх" жил болгон зарласан жилийн ажлын дүнг хэлэлцэж "Удирдах ажилтны зөвлөгөөн"-ий илтгэлд дурьдаж тайлагнахаар болов..</p> <p>5. ТАЗ-ийн өгсөн үүрэг чиглэлийн дагуу 2016 оныг "Ил тод байдлыг хангах, ажлын хариуцлагыг дээшлүүлэх жил" болгон зарлахаар тогтож Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн тогтоол гарган сумдын засаг даргын тамгын газар, хэлтэс агентлагуудад хүргүүлж хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахаар тогтов.</p>
3	Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн хуралдаан №03	2016.03.01	<p>1.Төрийн захиргааны албан хаагчийн зэрэг дэв олгох тухай</p> <p>2. Төрийн албаны салбар зөвлөлд ирүүлсэн санал хүсэлтийн тухай</p> <p>-Сайхан сумын иргэн Г.Ганцэцэг</p> <p>3."Төрийн албаны тэргүүний ажилтан" цол тэмдгээр шагнуулах тухай</p>	<p>1.Төрийн захиргааны албан хаагчийн зэрэг дэв олгох тухай асуудлыг хэлэлцэж 99 төрийн захиргааны албан хаагчид зэрэг дэв олгохоор аймгийн засаг даргад уламжлахаар тогтов.</p> <p>2. Сайхан сумын иргэн Г.Ганцэцэгийн өргөдлийн дагуу Цагааннуур сумын ЗДТГ-ын даргад ТАЗСЗ-ийн албан бичгээр хариуг хүргүүлэхээр</p>



Төрийн албаны зөвлөлийн
Сэлэнгэ аймаг дахь салбар зөвлөл



			<p>-Хүүхэд гэр бүлийн хөгжлийн хэлтсийн дарга П.Оюун</p> <p>-Байгаль орчин аялал жуулчлалын газрын ойн албаны дарга Г.Цэнгэлзаяа</p>	<p>шийдвэрлэсэн.</p> <p>3."Төрийн албаны тэргүүний ажилтан" цол тэмдгээр шагнуулахаар тодорхойлсон</p> <p>Хүүхэд гэр бүлийн хөгжлийн хэлтсийн дарга П.Оюун, Байгаль орчин аялал жуулчлалын газрын ойн албаны дарга Г.Цэнгэлзаяа нарын шагналын баримт бичгийг бүрдүүлэн Төрийн албаны зөвлөлд уламжлахаар тогтсон.</p>
4	Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн хуралдаан №04	2016.03.30	1.Төрийн захиргааны албан тушаалын сул орон тоог нөөцөөс нөхсөн арга хэмжээний тухай	1.Төрийн захиргааны албан тушаалын сул орон тоог нөөцөөс нөхсөн арга хэмжээний дагуу аймгийн НХД-ийн Дулаанхаан тосгоны байцаагчийн албан тушаалд-2, Номгоны томгоны газрын даамлын албан тушаалд- 1 хүн бүртгүүлснийг хэлэлцэж 2 хүнийг нэр дэвшүүлэхээр тогтов.
5	Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн хуралдаан №05	2016.04.20	1.Төрийн захиргааны албан тушаалын сул орон тоо, төрийн албаны мэргэшлийн шалгалтын тухай мэдээлэл	1.Төрийн захиргааны албан тушаалын сул орон тоо, төрийн албаны мэргэшлийн шалгалтын тухай мэдээлэл хийж сул орон тооны зарыг Төрийн албаны зөвлөлд хүргүүлэхээр тогтов.
			2. Төрийн албаны салбар зөвлөлд ирүүлсэн өргөдөл, гомдлын тухай Мандал сумын иргэн Х.Уламбаяр Түшиг сумын иргэн Л.Сарангэрэл	2. Мандал сумын иргэн Х.Уламбаярын аймгийн засаг даргад хандсан өргөдлийг С.Отгонжаргал даргатай ажлын хэсэг газар дээр нь шалгаж хариу өгөхөөр шийдвэрлэв.
			3."Төрийн албаны тэргүүний ажилтан" цол тэмдгээр шагнуулах тухай Хилийн мэргэжлийн хяналтын албаны мэргэжилтэн Т.Тунгалагтуяа	Түшиг сумын иргэн Л.Сарангэрэлийн өргөдлийн дагуу хэлэлцэж Түшиг сумын ЗДТГ-ын даргад ТАЗСЗ-ийн 2016 оны 31 дугаар албан бичгээр хариуг хүргүүлэв.
				3."Төрийн албаны тэргүүний ажилтан" цол тэмдгээр шагнуулахаар тодорхойлсон Хилийн мэргэжлийн хяналтын албаны мэргэжилтэн Т.Тунгалагтуяагийн шагналын баримт бичгийн бүрдлийг ханган Төрийн албаны зөвлөлд уламжлахаар тогтов.



Төрийн албаны зөвлөлийн
Сэлэнгэ аймаг дахь салбар зөвлөл



6	Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн хуралдаан №06	2016.04.25	<p>1. Төрийн албаны салбар зөвлөлд ирүүлсэн өргөдөл, гомдлын тухай</p> <p>Сүхбаатар сумын иргэн Ч.Байгалмаа</p> <p>НДХ-ийн мэргэжилтэн Н.Нарангэрэл</p> <p>Сүхбаатар сумын иргэн Ж.Уянга</p>	<p>Сүхбаатар сумын иргэн Ч.Байгалмаагийн өргөдлийн дагуу Аймгийн НДХ-ийн даргад ТАЗСЗ-ийн албан бичиг хүргүүлж хариуг шийдвэрлэхийг даалгав.</p> <p>НДХ-ийн мэргэжилтэн Н.Нарангэрэлийн сахилгын шийтгэл ноогдуулсан шийдвэрийг үндэслэлтэй гэж үзэж хариуг хүргүүлэхээр тогтов.</p> <p>Сүхбаатар сумын иргэн Ж.Уянгын өргөдөл, гомдлыг хэлэлцэж Аймгийн ХХААГ-ын даргад ТАЗСЗ-ийн албан бичгээр хариуг хүргүүлж гомдлыг барагдуулахыг даалгав.</p>
7	Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн хуралдаан №07	2016.07.19	<p>1.Төрийн албаны тэргүүний ажилтан цол тэмдгээр шагнагдсан хүний шагнал гардуулах</p> <p>-БОАЖГ-ын албаны дарга Г.Цэнгэлзаяа</p> <p>-АЗДТГ-ын НХХ-ийн мэргэжилтэн Д.Нансалмаа</p> <p>2.Төрийн албаны зөвлөлөөс 2015 оны ажлаараа тэргүүлсэн “Батламж” гардан авсан тухай</p> <p>3. Төрийн албаны салбар зөвлөлд ирүүлсэн өргөдөл, гомдлын тухай</p> <p>Баянгол сумын ЗДТГ-ын газрын даамал Т.Саранцэцэг</p> <p>Сүхбаатар сумын иргэн Д.Бат-Итгэл</p> <p>Жавхлант сумын ЗДТГ-ын мэргэжилтэн Б.Сарантуяа</p> <p>4.“Төрийн албаны тэргүүний ажилтан” цол тэмдгээр шагнуулах тухай</p> <p>- Сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүгч С.Нолхоосүрэн</p> <p>-Татварын хэлтсийн татварын улсын байцаагч Д.Энхцэцэг</p> <p>- Аймгийн ЗДТГ-ын ахлах мэргэжилтэн Б.Оюун</p> <p>- Санхүү, дотоод аудитын</p>	<p>Төрийн албаны тэргүүний ажилтан цол тэмдгээр шагнагдсан БОАЖГ-ын албаны дарга Г.Цэнгэлзаяа, АЗДТГ-ын НХХ-ийн мэргэжилтэн Д.Нансалмаа нарын шагналыг ТАЗСЗ-ийн дарга Ө.Сувдаа гардуулав.</p> <p>2. Төрийн албаны зөвлөлөөс 2015 оны ажлаараа тэргүүлсэн “Батламж” гардан авсан тухай ТАЗСЗ-ийн дарга Ө.Сувдаа танилцуулж баяр хүргэв.</p> <p>3. Баянгол сумын ЗДТГ-ын газрын даамал Т.Саранцэцэгийн сахилгын шийтгэлийг хүлээн зөвшөөрөхгүй байгаа тухай гомдлыг дахин магадалж хариу өгөхийг Баянгол сумын Засаг даргад даалгасан албан тоот явуулахаар тогтов.</p> <p>- Жавхлант сумын ЗДТГ-ын мэргэжилтэн Б.Сарантуяагийн ажлаас чөлөөлөгдсөн шийдвэрийг үндэслэлтэй гэж үзэж тогтоол гарган хүргүүлэхээр тогтов.</p> <p>3. “Төрийн албаны тэргүүний ажилтан” цол тэмдгээр шагнуулахаар тодорхойлсон Сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүгч С.Нолхоосүрэн, Татварын хэлтсийн татварын улсын байцаагч Д.Энхцэцэг, аймгийн ЗДТГ-ын ахлах</p>



Төрийн албаны зөвлөлийн
Сэлэнгэ аймаг дахь салбар зөвлөл



			албаны дарга Б.Дарихжав - Аймгийн ОБГ-ын дарга Г.Баатар	мэргэжилтэн Б.Оюун, Санхүү, дотоод аудитын албаны дарга Б.Дарихжав, аймгийн ОБГ-ын дарга Г.Баатар нарын шагналын материалыг Төрийн албаны зөвлөлд уламжлахаар тогтов.
8	Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн хуралдаан №08	2016.11.24	<p>1. Төрийн албаны салбар зөвлөлд ирүүлсэн өргөдөл, гомдлын тухай</p> <ul style="list-style-type: none"> - Сүхбаатар сумын иргэн Б.Болорцэцэг - Хушаат сумын ЗДТГ-ын мэргэжилтэн З.Цолмон - Сүхбаатар сумын иргэн Д.Баянжаргал - Сүхбаатар сумын иргэн Д.Энхжаргал - Сүхбаатар сумын иргэн С.Жавзандулам - Сүхбаатар сумын иргэн Д.Бат-Итгэл <p>2.“Төрийн албаны тэргүүний ажилтан” цол тэмдгээр шагнуулахаар ирүүлсэн төрийн албан хаагчдын тухай</p> <ul style="list-style-type: none"> -Сүхбаатар сумын ЗДТГ-ын дарга Д.Энхзаяа -Ерөө сумын Бугант тосгоны захирагчийн албаны ажилтан М.Туяна -Орхонтуул сумын -Татварын улсын байцаагч Д.Чимгээ -Сэлэнгийн долгио чуулганы дарга Д.Уранбилэг <p>3.Алтанбулаг сумын ЗДТГ-ын дарга, Алтанбулаг, Баянгол сумын ИТХ-ын нарийн бичгийн даргын албан тушаалд томилогдох ажилтны сонгон шалгаруулалтын дүнгийн тухай</p>	<p>1. Сүхбаатар сумын иргэн Б.Болорцэцэгийн өргөдлийг хэлэлцэж ТАЗСЗ-ийн тогтоолоор ажлаас халсан шийдвэрийг үндэслэлтэй гэж үзэж хариуг хүргүүлэхээр болов.</p> <ul style="list-style-type: none"> -Хушаат сумын ЗДТГ-ын мэргэжилтэн З.Цолмонгийн цалингийн зэрэглэл ахиулах асуудлаар Хушаат сумын ЗДТГ-ын даргад албан тоот хүргүүлэхээр тогтов. - Сүхбаатар сумын иргэн Д.Баянжаргалыг аймгийн БСГ-ын мэргэжилтнээр томилох асуудлыг шийдвэрлэхийг аймгийн БСГ-ын даргад даалган албан тоот хүргүүлэхээр тогтов. - Сүхбаатар сумын иргэн Д.Энхжаргалын өргөдлийг шалгах ажлын хэсэг томилон ажиллуулахаар болов. - Сүхбаатар сумын иргэн С.Жавзандуламд харъяалагдах салбар зөвлөлдөө хандахыг зөвлөсөн албан тоот хүргүүлэхээр болов. - Сүхбаатар сумын иргэн Д.Бат-ИтгэлынГХБХБГ-ын мэргэжилтэнтэй холбоотой асуудлыг ажлын хэсэг томилон шалгуулахаар тогтов. <p>2.Төрийн албаны тэргүүний ажилтан” цол тэмдгээр шагнуулахаар ирүүлсэн Сүхбаатар сумын ЗДТГ-ын дарга Д.Энхзаяа, Ерөө сумын Бугант тосгоны захирагчийн албаны ажилтан М.Туяна, Орхонтуул сумын Татварын улсын байцаагч Д.Чимгээ, Сэлэнгийн долгио чуулганы дарга Д.Уранбилэг нарыг шагналын материалыг бүрдүүлэн Төрийн албаны зөвлөлд уламжлахаар тогтов.</p> <p>3. Алтанбулаг сумын ЗДТГ-ын</p>



Төрийн албаны зөвлөлийн
Сэлэнгэ аймаг дахь салбар зөвлөл



				дарга, Алтанбулаг, Баянгол сумын ИТХ-ын нарийн бичгийн даргын албан тушаалд томилогдох ажилтны сонгон шалгаруулалтын дүнг хэлэлцэж хамгийн өндөр оноо авсан 3 хүнийг нэр дэвшүүлэхээр тогтов.
--	--	--	--	---

Төрийн жинхэнэ албан хаагчийн нөөцийн сангийн судалгаа:

№	Шалгалт болсон огноо	Сул ажлын байрны тоо	Тэнцсэн хүний тоо	1-ээр гарсан хүний тоо	Нөөцөөс нөхсөн	Шилжүүлсэн	Нөөцөд бүртгэлтэй хүний тоо
1	2015.05.15	27	51	15	1	1	34
2	2015.11.09	36	63	22	1	2	38
	2015 оны нийт	63	114	37	2	3	72
1	2016.05.09	14	67	11	0	1	51
2	2016.12.08	27	96	14	0	1	81
	2016 оны нийт	41	163	25	0	2	132
	Нийт дүн	104	277	62	2	5	204

Төрийн захиргааны албан хаагчийн зэрэг дэв олгосон байдлыг сүүлийн 10 жилийн байдлаар үзүүлбэл:

Төрийн захиргааны албан тушаалын ангилал	2007 он - 2016 он									
	2007 он	2008 он	2009 он	2010 он	2011 он	2012 он	2013 он	2014 он	2015 он	2016 он
Ахлах тшмэл	3	7	3	6	6	3	2	10	5	7
Дэс түшмэл	15	23	25	42	43	62	48	60	39	69
Туслах түшмэл	30	21	11	22	20	25	37	27	40	23
Нийт дүн	48	51	39	70	69	90	88	97	84	99



Төрийн албаны зөвлөлийн
Сэлэнгэ аймаг дахь салбар зөвлөл



Төрийн албаны хууль тогтоомжийн болон хэрэгжилтийн талаарх төрийн байгууллагаас хийж хэрэгжүүлж буй ажил арга хэмжээний талаарх мэдээлэл авах боломжоор хангах үүднээс аймгийн **“Selenge.gov.mn”** цахим хуудсанд цаг үеийн шуурхай мэдээллүүдийг байршуулж, аймгийн Засаг даргын Тамгын газрын сар тутмын **“Өргөн Сэлэнгэ”** мэдээллийн сонин гарган үйлчилж байна. Сонины дугаар бүрт төрийн үйлчилгээний үйл ажиллагааны талаар иргэдээс мэдээлэл авах утас, хаяг, хариу мэдээллийг тогтмол нийтэлдэг болсон. Энэхүү мэдээллийн хуудсыг 17 сум, 6 тосгонд тухай бүр хуваарилан хүргүүлж иргэдэд түргэн шуурхай хүргэх ажлыг зохион байгуулж хэвшлээ.

Орон нутгийн “Миний Монгол” телевизийн “Иргэдээ сонсьё” шууд нэвтрүүлэгт 2016 оны 6, 12 дугаар сард Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн дарга гишүүд оролцож, салбар зөвлөлийн үйл ажиллагааны болон төрийн албаны мэргэшлийн шалгалтын талаар танилцуулж иргэдийн сонирхсон асуултанд хариуллаа.

Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн самбарт Монгол Улсын Төрийн албаны зөвлөл, Салбар зөвлөлийн шийдвэр, цаг үеийн мэдээ, мэдээлэл, төрийн албан хаагчдын тоо бүртгэлийн талаар болон хийж хэрэгжүүлж буй ажил арга хэмжээг самбарт байршуулж сурталчлах ажлыг тогмолжуулаад байна. Мөн төвийн “Зууны мэдээ” сонин, Монголын үндэсний болон TV-9 телевиз орон нутгийн, “Сэлэнгийн мэдээ”, “Шинэ гэгээ” сонин “Миний Монгол” кабелийн телевиз, аймгийн Засаг даргын Тамгын газраас эрхлэн гаргадаг “Өргөн Сэлэнгэ” сар тутмын мэдээллийн сонин зэрэг хэвлэл мэдээллийн хэрэгслэлээр Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлөөс явуулж буй цаг үеийн ажил арга хэмжээний талаар ярилцлага өгөх, нийтлэх зэргээр сурталчлах ажлуудыг зохион байгуулан ажиллаж байна.

Төрийн албаны зөвлөлийн шийдвэрээр аймаг, нийслэлийн салбар зөвлөлүүдээс 2015 оны ажлын үр дүнгээр дэд байр эзэлж “Өргөмжлөл” хүртсэнийг аймгийн цахим хуудас, салбар зөвлөлийн самбарт байршуулж мэдээллээ.



Төрийн албаны зөвлөлийн
Сэлэнгэ аймаг дахь салбар зөвлөл



2016 онд Төрийн албаны зөвлөлөөс ирсэн тогтоол, зөвлөмж, заавар журмын мөрөөр хийсэн ажлын талаарх судалгааг дараах байдлаар гаргалаа.

**Төрийн албаны зөвлөлөөс 2016 онд ирсэн
албан бичгийн шийдвэрлэлт:**

№	Огноо	Дугаар	Хаанаас ирсэн	Бичгийн утга	Хэрэгжилт
Хугацаатай тайлан мэдээний тухай					
1	2016.04.07	335	Төрийн албаны зөвлөл	Судалгаа авах тухай	ТАЗСЗ-ийн 2016 оны 25 дугаар албан бичгээр нутгийн захиргааны байгууллагын удирдах, гүйцэтгэх албан тушаал, төрийн үйлчилгээний гүйцэтгэх албан тушаалд түр орлон гүйцэтгэгчээр ажиллаж буй 24 байгууллагын 37 хүний судалгааг гаргаж хүргүүлсэн.
2	2016.04.19	405	Төрийн албаны зөвлөл	Баримт бичиг ирүүлэх тухай	ИХШХЕГ-ын Сэлэнгэ аймаг дахь газрын Алтанбулаг авто замын боомтын төрийн жинхэнэ албан тушаалд нэр дэвшсэн Ганболдын Ган-Эрдэнийн мэргэглийн шалгалтын баримт бичгийг 2016 оны 27 дугаар албан бичгээр хүргүүлсэн.
3	2016.06.08	599	Төрийн албаны зөвлөл	Судалгаа ирүүлэн тхай	Төрийн албан хаагчийн тоо бүртгэлийн судалгааг холбогдох маягтын дагуу гаргаж 2016 оны 41 дугаар албан бичгээр хүргүүлсэн.
4	2016.08.23	847	Төрийн албаны зөвлөл	Э.Ариунгоогийн тухай	Төрийн албаны мэргэшлийн шалгалтаар хамгийн өндөр оноо авч томилохгүй байгаа тухай номдол мэдүүлсэн. Жавхлант сумын ЗДТГ-ын төрийн сангийн мэргэжилтнээр томилогдон ажиллаж байна.
Тогтоол, заавар, зөвлөмжийн талаар:					
1	2016.03.04	314	Төрийн албаны зөвлөл	Зөвлөмж хүргүүлэх тухай	Зөвлөмжийн хэрэгжилтийг ханган ажиллаж төрийн албаны зөвлөлд хагас, бүтэн жилийн байдлаар тайлагнав.
2	2016.06.10	637	Төрийн албаны зөвлөл	Тогтоол хүргүүлэх тухай	“Төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцөд бүртгэж, нэр дэвшүүлэх тухай” 2016 оны 63 дугаар тогтоолыг хүлээн авч холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлж хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллалаа.
3	2016.12.26	1464	Төрийн албаны	Тогтоол	“Төрийн жинхэнэ албан тушаалд



Төрийн албаны зөвлөлийн
Сэлэнгэ аймаг дахь салбар зөвлөл



			зөвлөл	хүргүүлэх тухай	анх орох иргэний нөөцөд бүртгэж, нэр дэвшүүлэх тухай” 2016 оны 258 дугаар тогтоолыг хүлээн авч холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлж хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллалаа.
--	--	--	--------	-----------------	--

Тайлант онд Төрийн албаны зөвлөлөөс судалгаа, тайлбар ирүүлэх тухай хугацаатай 4, салбар зөвлөлийн чиг үүрэгтэй холбоотой тогтоол, заавар, зөвлөмж 3 ирснийг бүртгэн холбогдох арга хэмжээг авч хугацаанд нь тайлагнах ажлыг зохион байгууллаа.

ДҮГНЭЛТ:

Төрийн албатай холбоотой хууль тогтоомж, Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журмыг үйл ажиллагааныхаа удирдлага болгон тайлант оныхоо зорилго, зорилтын хэрэгжилтийг хангах, орон нутгийн хүний нөөцийн чадавхийг хөгжүүлэх, стандартын удирдлагаар ханган мэргэшил арга зүй, бодлогын дэмжлэг үзүүлэх, үр дүнд суурилсан хяналт-шинжилгээ, үнэлгээний тогтолцоог нэвтрүүлэхэд гол үйл ажиллагаагаа чиглүүлэн төлөвлөсөн ажил арга хэмжээг амжилттай хэрэгжүүлэн ажиллалаа.

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН
САЛБАР ЗӨВЛӨЛ